

Хэвсгөл аймгийн аудитын газарт

Аймгийн ИТХ-д бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр

Зорилго: Сумынхаа ард иргэдийн эрх ашгийг эрхэмлэн эрүүл амьдрах, ажилтай, орлоготой, аз жаргалтай, ирээдүйдээ итгэх хүсэл эрмэлзэлтэй нь хамтран ажиллаж үр дүнд хүрэхэд оршино.


Зорилт: Баг, сум, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд иргэдийнхээ санал, хүсэлт, үзэл бодлыг нь хүргэж бодит ажил болгоход санаачлагатай ажиллах

Дээрхи зорилго, зорилтонд хүрэхийн тулд доорхи 3-н ажилд тулгуурлан мөрийн хөтөлбөр дэвшүүж байна.

1. "Эрүүл сайхан амьдарцгаая" аяныг хэрэгжүүлэхийн тулд эрүүл мэнд, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран иргэдээ эрсдэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоо, шинжилгээнд бүрэн хамруулж эмчлэх, эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах, сургаж чадавхжуулах, орчин үеийн эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах, спорт, соёл урлаг, нийгмийн бүхий салбарт манлайлагчдыг бий болгоход анхаарч сургалт, бэлтгэлийг үе шаттай, тогтвортой зохион байгуулах, "Чийрэгжүүлэлтийн танхим"-тай болгох зэрэг ажлуудыг хийнэ.
2. "Нутагтаа сайхан амьдарцгаая" аяныг бүх шатны иргэдийн хурал, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран төрийн албан хаагчид, сумын төвийн иргэд, малчдаа сууцны байшинтай болгох, фермерийн болон өндөр ашигт мал аж ахуйг хөгжүүлэх, жимсний мод, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалах, билчээр хамгаалах, худаг гаргах, гол, булгийн эхийг хаших, хамгаалах, шар усны ус тогтоон цөөрөм бий болгох, мод тарих, мал эрүүлжүүлэх ажлыг хөтөлбөрийн дагуу эрчимтэй зохион байгуулж түүхий эдийг өндөр үнээр зах зээлд борлуулах боломжоор хангах, мал хулгайлах болон бусад гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх сургалт, мэдээлэл хийх, малчид болон нийт өрхийг үйлдвэрлэгч болгох. "Улсын тэргүүний сум" болгохын төлөө ажиллана.
3. "Төрдөө итгэж амьдарцгаая" аяныг бүх шатны ИТХурал, иргэд, төрийн болон ТББ, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ард түмний төлөөллөөс бүрдсэн "Хяналтын хороо"-г байгуулан төрийн өмчийн ашиглалт, төсвийн мөнгөний зарцуулалт, төсөл, хөтөлбөрийн сонгон шалгаруулалт, хэрэгжилтэнд хяналт тавих, дэмжих, хариуцлага тооцуулахаар холбогдох газар нь уламжлах, төрийн албан хаагчдийг ёс зүй, үр чадвар, хариуцлагатай ажиллуулах талаар зөвлөгөөн, ярилцлага, хэлэлцүүлэг хийж байх, хүний эрх, эрх тэгш харилцаа, хууль дээдлэх ёсыг баримтлах, сумын иргэдийн саналаар "засаг даргаа сонгогдог байх" сонголтыг хуулиар баталгаажуулахын тулд УИХ-ын уламжлах зэрэг ажлуудыг хийнэ.

Боловсруулсан: Бие даан нэр дэвшигч Санжаажамцын Баянмөнх / 

Утас №99387906

 3. ДН

0000001